



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 21191

Улаанбаатар хот

Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын
“Хүн төвт хөгжлийн төлөвлөгөө”-г батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын “Хүн төвт хөгжлийн төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, зохих удирдлагаар хангаж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Л.Оюунжаргал)-т даалгасугай.

3. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хууль тогтоомжийн дагуу санхүүжүүлэн зохион байгуулахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Л.Оюунжаргал)-т зөвшөөрсүгэй.

Б.Бат-Эрдэнэ



Б.БАТ-ЭРДЭНЭ

152400523

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны 1 дугаар сарын 17-ны өдрийн
21/191 дугаар тушаалын хавсралт

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН
"ХҮН ТӨВТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ"
(2024-2028 он)

НЭГ.ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын эдийн засаг, үндэсний аюулгүй байдлын үндэс болсон бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн үйлдвэрлэл зэрэг салбарууд нь байгаль цаг агаарын эрхшээлд оршсоор байна. Орчин үеийн дэлхийн уур амьсгалын эрчимтэй дулаарлын улмаас цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэн, учруулах эрсдэлийн хамрах хүрээ улам бүр тэлж байна.

Монгол Улсын нутаг дээр цаг агаарын ажиглалт, хэмжилт хийж эхэлснээс хойш 100 жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.46 хэмээр нэмэгдэж, улирлын хур тунадасны горим өөрчлөгдөж, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер зэрэг цаг агаарын аюултай үзэгдлийн давтагдал нэмэгдэж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь Монгол орны мөнх цэвдэг гэсэх, мөнх цас, мөсөн гол хайлах явцыг эрчимжүүлж, цөлжилт, газрын доройтол, ойн хомсдол үүсгэн, ургамал нөмрөг, амьтны аймагт шууд болон дам байдлаар нөлөөлж байдаг. Нөгөө талаас хүн амын өсөлт, хотжилт, аж үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуйн хөгжлийн хурдацтай өсөлтөөс үүдэлтэй орчны доройтол нь улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын амьжиргаанд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлсээр байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт цаг уурын тогтмол ажиглалт анх 1924 онд хийгдэж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээнд 318 цаг уурын өртөө, харуул (300 сум, 11 баг, тосгон, 7 дүүрэг, хороо), агаар мандлын дээд давхаргыг судлах 4 станц, шар шороон шуурганы 9 станц, хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах 2 станц, доплерын радарын 2 станц, ус судлалын 154 харуул, орчны хяналт шинжилгээний 22 лаборатори, агаарын чанарын хяналтын 36 станц, хүчиллэг тунадасны 2 станц, усны чанарын 194, хөрсний чанарын 400, бэлчээрийн төлөв байдлын 1550 цэгт тогтмол ажиглалт, хэмжилт хийж байна.

Ус, цаг уурын өртөө, харуулыг автомат станцаар 100 хувь хангаж, радарын сүлжээ бий болгон, суперкомпьютерын хүчин чадлыг нэмэгдүүлснээр ус, цаг агаарын болон агаарын бохирдлын бүх төрлийн урьдчилсан мэдээний таарцыг 0.2-10 хүртэл хувиар нэмэгдүүлж, гамшигт үзэгдлийг эртнээс сэрэмжлүүлж, эрсдэлийг бодитоор бууруулах, нислэгийн цаг уурын үйлчилгээг оновчтой үр ашигтай болгох боломжтой болох юм.

Цаг уурын нийт өртөө, харуулын 120 нь автомат станцгүй байгаас цаг уурын хэмжилтийг механик, мөнгөн уст багажаар хийсээр байгаа нь Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын хэрэгжилт болон Дэлхийн цаг уурын байгууллагын мөнгөн уст хэмжих хэрэгсэл ашиглахыг зогсоох тухай зөвлөмжийн хэрэгжилтийг зөрчиж байна. Мөн мөнгөн уст хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл дэлхийн хэмжээнд зогссон, мөнгөн усыг хилээр нэвтрүүлэхэд хязгаарлалт тогтоосон зэрэг шалтгааны улмаас хэмжих хэрэгслийн хомсдол үүсэж, цаг уурын анхан шатны мэдээний цуваа тасарч, уур амьсгалын өөрчлөлт, хэт халалт, хөрөлтийг хэмжихгүй өнгөрөх, судалгаа, шинжилгээний ажил хийх боломжгүй болох нөхцөл бий болж, урьдчилсан мэдээний чанарт сөргөөр нөлөөлж байна.

Цаг агаарын зарим аюултай үзэгдлийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор анх 1978 онд Морин-Ууланд Зөвлөлт Холбоот Улсын МРЛ-2 радиолокаторын станцыг байгуулсан ба 1999 онд Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд

Доплерийн эффект бүхий С-төрлийн радараар сайжруулан сольсон байдаг. Тус радар нь 24 дэх жилдээ тасралтгүй ажиллаж байгаа хэдий ч техник, технологийн хувьд хуучирч, сэлбэгийн нөөц дууссанаас сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа нь доголдох болсон. Ингэснээр уруйн үер, аянга, мөндөр, нөөлөг салхи зэрэг цаг агаарын гамшгаас Улаанбаатар хот болон 200 км-ийн дотор байрлах сумдын иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах боломжгүй болохоос гадна олон улсын болон орон нутгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа тасрах нөхцөл бий болоод байна.

Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль журмын хүрээнд орчны чанарын шинжилгээг хийж, үнэлгээ, дүгнэлт гаргаган бодлого боловсруулахад суурь мэдээлэл болгон ашигладаг билээ. Орчны хяналт, шинжилгээний лабораториуд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хөтөлбөрийн хүрээнд агаар, ус, хөрсний чанар, хаягдал усны хяналт шинжилгээг өдөр бүр хийж байна. Орчны хяналт, шинжилгээг гар (механик) аргаар, олон нэр төрлийн химийн бодистой харьцан хийдэг, зориулалтын байргүй зэрэг нь Сорилтын лабораторид тавигдах MNSISO17025:2018 стандартын шаардлагыг хангахгүй байгаа тул зориулалтын лабораторийн байртай болох, техник технологийн шинэчлэл хийх, автоматжуулах шаардлага тулгарч байна.

2023 оны байдлаар аймаг, нийслэл дэх Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн ажлын байрууд өрөөний хүртээмж тааруу, ихэнх нь ариун цэврийн өрөөгүй, цаг уурын өртөөдийн 80 хувь нь шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж, 33 харуул гэрээсээ ажлаа эрхэлж байна.

Монгол Улсын хүн бүрийг ус, цаг агаар, орчны аюултай үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлж, нийгмийг орчны бохирдолын бодит мэдээллээр хангаж, улсын нийгэм, эдийн засагт үүсэж болзошгүй байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, шинжлэх ухаанд суурилсан бодлогын оновчтой шийдвэр гаргахад дэлхийн болон олон улсын цаг уурын байгууллагын хөгжлийн чиг хандлагыг баримтлан Монгол Улсын цаг уурын үйлчилгээний хөгжлийн талаар баримтлах бодлого боловсруулах, салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үндэсний сүлжээг өргөтгөх, техник технологийг шинэчлэх, автоматжуулах, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх, салбарын хүний нөөц, нийгмийн баталгааг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Дэлхийн цаг уурын байгууллагын стратегийн "Ус, цаг уурын гаралтай гамшигт үзэгдлийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, дасан зохицох чадавхыг бий болгоход уур амьсгалд "ухаалаг" шийдвэр гаргадаг байх, цаг агаар, уур амьсгал, ус, орчны үйлчилгээний нийгэм эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх" гэсэн гол зорилт болон НҮБ-ийн "Эрт сэрэмжлүүлгийг хүн бүрд" санаачилгатай уялдуулан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын "Хүн-төвт" хөгжлийн төлөвлөгөөг боловсруулав.

Энэхүү хүн төвтэй хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд нийгмийг орчин үеийн шаардлагад нийцсэн чанартай, хүртээмжтэй ус, цаг уур, орчны шинжилгээний мэдээллээр хангаж, салбарын зүгээс улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдлыг хангахад оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг тусгасны зэрэгцээ ус, цаг уурчдын хөгжил, нийгмийн баталгааны асуудлыг өргөн хүрээнд авч үзэж холбогдох асуудлыг шийдвэрлэхээр тусгасан.

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2020-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.13-д "Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, таваас доошгүй байршилд радарын станц байгуулна" гэж, Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.3-д "Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах" гэж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.12.5 болон

5.1.12.8-д “Хэнтий, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн төвд радарын суурилуулж, радарын сүлжээ бий болгох, цаг уурын автомат станц 100 ширхгийг суурилуулах” гэж тус тус туссан. Энэхүү төлөвлөгөөг Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд байгаль орчин, ус цаг уурын салбарын талаар дэвшүүлсэн зорилт, Дэлхийн цаг уурын байгууллагын стратегийн гол зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн боловсруулсан.

ХОЁР.ЗОРИЛГО

Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлан уур амьсгалын өөрчлөлт, ус, цаг уурын болзошгүй гамшиг, орчны бохирдлоос улс орны нийгэм, эдийн засаг, аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг бууруулахад салбар бүрийн хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, чанартай мэдээ, мэдээллээр тэгш, хүртээмжтэй үйлчлэх, дэлхийн чиг хандлагатай нийцсэн салбарын товчтой хөгжлийг бий болгоно.

ГУРАВ.ЗОРИЛТ

Зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

3.1.Хөрөнгө оруулалт, урсгал зардлыг нэмэгдүүлэх замаар техник технологийн шинэчлэл хийж, ус, цаг уур, орчны улсын сүлжээний тасралтгүй тогтвортой байдлыг хангаж, ус, цаг агаарын урьдчилсан мэдээний орон зай, цаг хугацааны нарийвчлалыг бичил хэмжээст үзэгдлийг илрүүлэх хэмжээнд хүргэн хөгжүүлнэ.

3.2.Шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөгжүүлж, хиймэл оюун ухааны боломж, шийдлүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, салбар бүрийн хэрэглэгчдийн онцлогт нийцсэн мэдээ, мэдээллийн шуурхай, цахим платформтой болно.

3.3.Тогтвор суурьшилтай, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлнэ.

ДӨРӨВ.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1Хөрөнгө оруулалт, урсгал зардлыг нэмэгдүүлэх замаар техник технологийн шинэчлэл хийж, ус, цаг уур, орчны улсын сүлжээний тасралтгүй тогтвортой байдлыг хангаж, ус, цаг агаарын урьдчилсан мэдээний орон зай, цаг хугацааны нарийвчлалыг бичил хэмжээст үзэгдлийг илрүүлэх хэмжээнд хүргэн хүргэн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1.Ус, цаг уур, орчны улсын сүлжээг өргөтгөж, техник технологийн шинэчлэл хийнэ.

4.1.2.Багаж, хэмжил зүйн лабораторийг өргөтгөж, техник, технологийн шинэчлэл хийнэ.

4.1.3.Орчны чанарын хяналт - шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлнэ.

4.1.4.Олон улс, хот хоорондын сувгийн ашиглалт, дотоод сүлжээ, интернэтийн хурдыг нэмэгдүүлнэ.

4.2.Шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөгжүүлж, хиймэл оюун ухааны боломж, шийдлүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, салбар бүрийн хэрэглэгчдийн онцлогт нийцсэн мэдээ, мэдээллийн шуурхай, цахим платформ байгуулах зорилтын хүрээнд:

4.2.1Технологи, арга зүйн шинэчлэл хийж цаг агаар, уур амьсгал, ус, орчны урьдчилсан мэдээг чанартай гаргаж үйлчилнэ.

4.2.2.Ус, цаг агаар, орчны урьдчилан мэдээлэх системийг олон төрлийн гамшгаас эртнээс сэрэмжлүүлэх, нөлөөлөлд үндэслэсэн систем болгон хөгжүүлнэ.

4.2.3.Ус цаг уур, орчны шинжилгээний болон байгаль орчны мэдээллийн санг шинэ технологи, хайлтын систем бүхий ашиглахад хялбар цогц цахим систем болгоно.

4.2.6.Уур амьсгалын үйлчилгээний цар хүрээ, үр өгөөжийг дээшлүүлнэ.

4.2.7.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.2.8.Азийн улс орны нислэгийн цаг уурын байгууллагын жишигт хүрсэн агаарын навигацийн цаг уурын үйлчилгээ үзүүлнэ.

4.3.Тогтвор суурьшилтай, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1.Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.

4.3.2.Хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулна.

4.3.3.“Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжид хүний нөөцийн чадавх бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах болон бусад асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

ТАВ.ҮР ДҮН, ХЭРЭГЖИХ ХУГАЦАА, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

5.1.Анхан шатны ажиглалт хэмжилт, хяналт шинжилгээний чадавх сайжирч, судалгаа шинжилгээний ажил өргөжин, ус, цаг уурын үйлчилгээ чанартай, үр дүнтэй, шуурхай, оновчтой, ухаалаг болж, мэргэшсэн, тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцөөр хангагдсан байна.

5.2.Тус төлөвлөгөөг 2024-2028 онд хэрэгжүүлэх бөгөөд нарийвчилсан арга хэмжээг 9 дүгээр хэсэгт тусгасан.

5.3.Хэрэгжилтийг дүгнэхдээ 2023 оныг суурь үзүүлэлт болгоно. Хэрэгжилт, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын "Хүн төвт хөгжлийн төлөвлөгөө"-ний хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт

д/д	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь түвшин 2023 он	Зорилтот түвшин 2028 он	Шалгуур үзүүлэлтийн тайлбар
1	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний багаж, техник технологийг автоматжуулсан байдал, хувь	%	65.0	80.0	Автомат багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдлыг салбар бүрээр гаргаж дундажлана.
2	Ус, цаг агаарын аюултай, гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний онц, хувь	%	78.2	85.0	Улсын хэмжээний ончийг хувиан дунджаар авна.
3	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн арга, загварын тоо	тоо	5	30	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн арга
4	Мэргэжилтэй боловсон хүчний эзлэх хувь	%	66.0	70.0	Бакалавраас дээш боловсролтой

					мэргэжлийн боловсон хүчний эзлэх хувь
--	--	--	--	--	--

ЗУРГАА.ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Төсөл, арга хэмжээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

6.1. Улсын төсөв

6.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж

6.3. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

6.4. Хуулиар хориглогдоогүй бусад эх үүсвэр

ДОЛОО.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1.Цаг уур орчны шинжилгээний газар улсын хэмжээнд харьяа 26 байгууллагын хүрээнд хэрэгжүүлж, хэрэгжилтэд Байгаль орчин, аялал жуулчлалын яам хяналт тавина.

7.2.Хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох яамд, төрийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагуудын салбар дундын уялдаа зохицуулалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам ханган ажиллана.

НАЙМ.ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

8.1.Монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон жил бүрийн улсын жилийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг Цаг уур орчны шинжилгээний газар зохион байгуулна.

8.2.Цаг уур орчны шинжилгээний газрын хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн дүгнэлт, тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.3.Явцын хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

----oOo----

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ САЛБАРЫН “ХҮН ТӨВТ” ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Хүрэх түвшин (2024-2028)							Нийт санхүү-жилт, эх үүсвэр	Хэрэгжүүлэх байгууллага
				2024	2025	2026	2027	2028	Сая төг			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
Зорилт 1 Хөрөнгө оруулалт, урсгал зардлыг нэмэгдүүлэх замаар техник технологийн шинэчлэл хийж, ус, цаг уур, орчны улсын сүлжээний тасралтгүй тогтвортой байдлыг хангаж, ус, цаг агаарын урьдчилсан мэдээний орон зай, цаг хугацааны нарийвчлалыг бичил хэмжээст үзэгдлийг илрүүлэх хэмжээнд хүргэн хөгжүүлэх зорилтын хүрээнд Үйл ажиллагааны чиглэл 1.1. Ус, цаг уур, орчны улсын сүлжээг өргөтгөж, техник технологийн шинэчлэл хийнэ.												
1	Цаг уурын өртөө, харуулыг автомат станцаар тоноглох	Автомат багажаар тоногдсон өртөө, харуулын тоо	185	25	25	25	25	25	УТ 13,000.0	БОАЖЯ ЦУОШГ		
2	Зоо цаг уурын харуулыг автомат станцаар хангах	Автомат станцаар хангагдсан харуулын тоо	4	1	1	1		1	УТ 520.0	ЦУОШГ УЦУОСМХ		
3	Аймгийн нисэх буудлуудад нисэхийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай нөөц автомат станц суурилуулах	Суурилуулсан нөөц автомат станцын тоо	0	Говь-Алтай (1)	(Өмнөговь, Ховд) 2	(Увс, Баян-Өлгий) 2	(Дорнод, Хөвсгөл) 2	(Завхан, Булган) 2	УТ, 2,430.0	ЦУОШГ, НЦУТ		
4	"Чингис хаан" ОУНБ-д салхины шилжлэг илрүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	Тоног төхөөрөмж суурилуулсан эсэх /тийм, үгүй/	0		тийм				УТ, ГЗТ 7,000.0	ЦУОШГ, НЦУТ		
5	Хос туйлт 250 км-ээс их алслагдтай 5 суурин радартай болох	Радарын тоо	1		(Өвөрхангай Хөвсгөл) 2	(Хэнтий) 1	(Ховд) 1	(Дундговь) 1	УТ, ГЗТ 42,000.0	БОАЖЯ, ЦУОШГ		
6	Ус судлалын харуулыг автомат багажаар тоноглох	Автомат багажтай харуулын тоо	0	17	5	5	5	5	УТ 4,200.0	БОАЖЯ, ЦУОШГ УЦУОСМХ		
7	Устөрөгч гарган авах шинэ техник, технологи нэвтрүүлэх	Шинэ технологи нэвтрүүлсэн харуулын тоо	1	1	1	1	1	1	УТ, ГЗТ 3,500.0	ЦУОШГ		

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
8	Өдөрт 3 удаа азрологийн хөөргөлт хийх	3 удаа хөөргөлт хийсэн станцын тоо	0			2	2	1	УТ, ГЗТ, 3.100.0	ЦУОШГ
9	Шинээр цаг уурын өртөө байгуулах	Шинээр байгуулсан өртөөний тоо,	-		4	2	3		УТ, ГЗТ, 2.250.0	БОАЖЯ, ЦУОШГ
10	Ус судлалын шинээр байгуулах	Шинээр нээсэн ус судлалын харуулын тоо,	-		7	1	1	1	УТ 1.200.0	БОАЖЯ, ЦУОШГ
11	Нислэгийн цаг уурын үйлчилгээний навигацгийн орлогод оруулж буй хувь нэмэрт үндэслэн агаарын навигацгийн орлогоос салбарын үйл ажиллагааг бэхжүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бий болгох	Эрх зүйн орчинг бүрдүүлж, санхүүжилтийн хувь	0	≤10						БОАЖЯ ЦУОШГ НЦУТ
12	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт, эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Жил бүр 100 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн санхүүжилт,	0	200	300	400	500	500	УТ 1.900.0	БОАЖЯ ЦУОШГ УЦУОСМХ
Үйл ажиллагааны чиглэл 1.2. Багаж, хэмжил зүйн лабораторийг өргөтгөж, техник, технологийн шинэчлэл хийнэ.										
13	Шалгалт, туршилт үйлдвэрлэлийн төв байгуулах	Төвийн тоо	0		1				УТ	ЦУОШГ БОХЗТЛ
14	Хэмжил зүйн бүсийн төв байгуулах	Бүсийн төвийн тоо	0			1		1	УТ	ЦУОШГ БОХЗТЛ
15	Хэмжил зүйн лабораторийн эталон хэмжих хэрэгсэл, шалгалт тохируулгын төхөөрөмжийг шинэчлэх	Шинэчилсэн хэмжих хэрэгсэл, шалгалт тохируулгын төхөөрөмжийн тоо,	10		35	50	80	100	УТ, ГЗТ 1.000.0	ЦУОШГ БОХЗТЛ
16	Шалгалт, туршилтын иж бүрэн тоноглогдсон талбай байгуулах	Тоноглогдсон талбай, хэрэгжилтийн явц	-	Төсөл бичих	Санхүүжилт эх үүсвэр шийдвэрлэсэн байна	Тоноглогдсон талбай байгуулна			УТ, ГЗТ 500.0	ЦУОШГ БОХЗТЛ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Үйл ажиллагааны чиглэл 1.3. Орчны чанарын хяналт - шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлнэ.										
17	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсийн лаборатори байгуулах	Бүсийн төвд байгуулсан лабораторийн тоо	0				2 /Өмнөговь, Өвөрхангай		УТ ГЗТ 500.0	ЦУОШГ УЦУОШТ
18	Орон нутгийн БОШЛ-ийн байрыг өргөтгөх	Өргөтгөсөн лабораторийн тоо	0	1			1		УТ 500.0	ЦУОШГ УЦУОШТ
19	Орон нутгийн БОШЛ-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Суурилуулсан төхөөрөмжийн тоо	0		2	4	6	8	УТ ГЗТ 1,100.0	ЦУОШГ УЦУОШТ
20	Аймгийн төвийн агаарын чанарын харуулыг автомат багажаар тоноглох	Автомат багаж суурилуулсан аймгийн тоо,	0	5	10	6			ГЗТ 31,201.6	ЦУОШГ УЦУОШТ
21	Байгаль орчны шинжилгээний төв лабораторийн чадавхыг сайжруулах	БОШЛ-ийн барилга, тоног төхөөрөмж суурилуулсан эсэх	Зөвлөх үйлчилгээ ний тендер дууссан	ТЭЗҮ боловсруулсан байна.	Барилгын ажил дуусаж, багаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна.	Үйл ажиллагаа эхэлсэн байна.			УТ, ГЗТ, 42,561,0	ЦУОШГ БОХЗТЛ
Үйл ажиллагааны чиглэл 1.4. Олон улс, хот хоорондын сүвгийн ашиглалт, дотоод сүлжээ, интернэтийн хурдыг нэмэгдүүлнэ.										
22	Улаанбаатар хотын харьяа байгууллагуудын интернэтийн хурдыг нэмэгдүүлэх	МВ	100		110	130	140	150	УТ 3,300	ЦУОШГ
23	Орон нутгийн харьяа байгууллагуудын интернэтийн хурдыг нэмэгдүүлэх	МВ	8		10	14	16	20	УТ 26.5	ЦУОШГ
Зорилт 2. Шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөгжүүлж, хиймэл оюун ухааны боломж, шийдлүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, салбар бүрийн хэрэглэгчдийн онцлогт нийцсэн мэдээ, мэдээллийн шуурхай, цахим платформтой болох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа										
Үйл ажиллагааны чиглэл 2.1. Технологи, арга зүйн шинэчлэл хийж цаг агаар, уур амьсгал, ус, орчны урьдчилсан мэдээг чанартай гаргаж үйлчилнэ.										
24	Суперкомпьютерыг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх,	Хүчин чадал, ТВ	6.8 ТВ	68 ТВ					ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
25	Тоон загварын сервер компьютерыг шинэчлэх	Сервер компьютерын хүчин чадал сайжруулах	128 Core 20TB	250 Core 30TB			250 Core 30TB		УТ, ГЗТ 850.0	ЦУОШГ, НЦУТ
26	Агаар мандал ба далайн харилцан үйлчлэлийг тооцсон дэлхийн хэмжээний динамик загварыг зүгшрүүлж, бүс нутгийн загвараар сайжруулан, сар, улирлын урьдчилсан мэдээнд ашиглах	Хэрэгжилтийн үе шат	Бүс нутгийн загвар байгаа	Дэлхийн хэмжээний динамик загварыг өөрийн оронд зүгшрүүлэх	Сар, улирлын урьдчилсан мэдээнд ашиглаж эхэлсэн байна	Сар, улирлын урьдчилсан мэдээнд ашигласан ансамбль аргыг нэвтрүүлсэн байна	Үр дүнг бүс нутгийн загвараар сайжруулан нарийвчилсан байна	Орон зайн нарийвчлал ыг 30 км хүргэсэн байна	УТ	ЦУОШГ УЦУОСМХ
27	Хиймэл дагуул, радар, дроны мэдээг боловсруулж, ассимиляци хийн, шинэ арга, технологи боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аргын тоо,	5	10	15	20	25	30	УТ	УЦУОСМХ
28	Хиймэл оюун ухаан ашиглаж урьдчилан мэдээлэх арга нэвтрүүлэх	Аргын тоо	1	1	2	3	4	5	УТ УЗТ	УЦУОСМХ
29	Инфакт фактор өндөртэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	Өгүүллийн тоо	0		2	3	4	5	УТ	УЦУОСМХ
30	Цаг агаарын урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх	5 хоногийн мэдээний Таарц хувь	88.6	88.7	89.0	89.2	89.3	89.4	УТ	ЦУОШГ УЦУОШТ-ҮҮД
31	Агаарын чанарын урьдчилсан мэдээний хамаарлыг сайжруулах	Урьдчилсан мэдээний хамаарал, хувь	65	67	70	75	80	85	УТ	ЦУОШГ УЦУОСМХ
32	Гол мөрний дундаж урсац, үерийн урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх	Урьдчилсан мэдээний таарц, нэмэгдсэн хувь	70	1	2	5	8	10	УТ	ЦУОШГ УЦУОСМХ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
33	Хөдөө аж ахуйн цаг уурын урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх	Урьдчилсан мэдээний таарц нэмэгдсэн хувь	1.65 2.14		1.8 2.2				УТ	ЦУОШГ УЦУОСМХ
Үйл ажиллагааны чиглэл 2.2. Ус, цаг агаар, орчны урьдчилан мэдээлэх системийг олон төрлийн гамшаас эртнээс сэрэмжлүүлэх, нөлөөлөлд үндэслэсэн систем болгон хөгжүүлнэ.										
34	Ус, цаг агаар, уур амьсгалын гамшигт үзэгдлийн эрсдэлийн үнэлгээг сумдын түвшинд хийж, эрсдэлийг бууруулах, эрт сэрэмжлүүлэхэд ашиглах	Цаг уурын гамшигын төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийсэн гүйцэтгэлийн хувь	Зарим судалгаа хийгдсэн	Төсөл боловсруулсан, үнэлгээ хийх арга зүйг батлуулсан байна	Санхүүжилт авсан, шаардагдах мэдээ, материалыг бэлтгэсэн байна	Цаг уурын гамшигын төрөлүүдээр бүх сум, дүүрэгт эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байна			УТ, ГЗТ	ЦУОШГ ОБЕГ
35	Олон төрлийн гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх, систем болгон хөгжүүлэх	Систем нэвтрүүлэх үе шат	Төслөөр туршилт судалгаа хийгдсэн	Туршилт судалгааг өргөжүүлэн цахим системийн эхлэл тавигдсан байна	Цахим системийг салбарын хэмжээнд өргөжүүлсэн байна	Нөлөөлөлд өртөх бүх салбарыг хамруулсан байна	Шийдвэр гаргах түвшинд ашиглагдах нэгдсэн системтэй болсон байна		УТ, ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ
36	Ус цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны явц,	-	Төсөл боловсруулна	Төсөл хэрэгжүүлнэ	Хүртээмжийг нэмэгдүүлэх хувилбар гарсан байна	Боломжит хувилбарыг хэрэгжүүлж эхэлсэн байна.	Бүрэн хэрэгжүүлсэн байна	ГЗТ	ЦУОШГ ОБЕГ
37	Олон нийтийн гамшигын тухай ойлголтыг дээшлүүлэх	Контентын тоо, үзэгчдийн хандалт,	16 контент 107000	19 контент 122000	22 контент 137000	25 контент 152000	28 контент 170000	31 контент 185000	УТ, ГЗТ	ЦУОШГ
Үйл ажиллагааны чиглэл 2.3. Ус цаг уур, орчны шинжилгээний болон байгаль орчны мэдээллийн санг шинэ технологи, хайлтын систем бүхий ашиглахад хялбар цогц цахим систем болгоно.										
38	Байгаль орчны мэдээллийн сангийн нэгдмэл байдлыг хангаж мэдээллээр баяжуулах, цахим үйлчилгээний нэгдсэн системийг хөгжүүлэх	Төрөлжсөн мэдээллийн сангийн тоо,	42	Системийг шинэчилнэ	46	47	48	тийм	УТ, ГЗТ	БОАЖЯ ЦУОШГ УЦУОСМХ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
39	Шинэ технологи, хайлтын систем бүхий ашиглахад хялбар цогц цахим системтэй болох	Хэрэгжилтийн явц,	0	Төсөл боловсруулах	Хамтрагч болон санхүүжүүлэгч байгууллага	Хэрэгжүүлэх			ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ
Үйл ажиллагааны чиглэл 2.4. Уур амьсгалын үйлчилгээний цар хүрээ, үр өгөөжийг дээшлүүлнэ.										
40	Монгол орны уур амьсгалын шинэчилсэн лавлах боловсруулах	цувааны урт /элементийн тоо	1940-1985 оноор, 70 гаруй элементээр тооцогдсон.	0	1940-2023 оноор/50 элемент	1940-2023 оноор/ 150 элемент			УТ 70.0	УЦУОСМХ
41	Монгол орны уур амьсгалын атлас боловсруулах	зураглалын тоо	0		30	70			ГЗТ 120.0	УЦУОСМХ
42	Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр тусгай хэрэглэгчид үйлчлэх чадавхыг бүрдүүлэх	Үйл ажиллагааны явц,	0	Хэрэглэгчийн судалгаа хийх	Мэдээлэл үйлчилгээний аргагүй боловсруулах	Туршилт хийх, Хэрэглэгчдэд таниулах	Хэрэглэгч олох	Үйлдвэрлэл д нэвтрүүлэх	УТ, ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ
43	ХАА салбарын хэрэглэгчид зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх	Хэрэгжилтийн явц	0	Хэрэглэгчийн судалгаа хийх	Шаардлагатай ажиглалт, аргагүй боловсруулах	Туршилт хийх хэрэглэгчдэд таниулах	Хэрэглэгч олох	Үйлдвэрлэл д нэвтрүүлэх	УТ, ГЗТ	ЦУОШГ УЦУОСМХ
44	Барилгад хэрэглэх уур амьсгалын шинэчилсэн стандарт норм, норматив боловсруулах	Стандарт, норм, нормативын тоо	47/36	-	30/12	47/36			УТ 70.0	УЦУОСМХ БХБЯ
Үйл ажиллагааны чиглэл 2.5. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.										
45	Мөндөр сарниулах шинэ технологи нэвтрүүлэх,	Үйл ажиллагааны явц,	0	Технологи судлах	Шаардлагатай тоног төхөөрөмж авах	Туршилт хийх	Нэвтрүүлэх		УТ 3,000.0	ЦУОШГ УЦУОШТ
46	Манан сарниулах шинэ технологи нэвтрүүлэх, %	Үйл ажиллагааны явц,	0	Технологи судлах	Шаардлагатай тоног төхөөрөмж авах	Туршилт хийх	Нэвтрүүлэх		УТ 3,000.0	ЦУОШГ УЦУОШТ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
47	Цаг агаари зориудаар нөлөөлөх ажлын үр ашгийг тооцох систем боловсруулах	Хэрэгжилтийн явц	Тайландын "Хааны Бороо" газартай хамтран ажиллах эхлэл тавигдсан	Технологи судлах	Шаардлагатай тоног төхөөрөмж, материал авах	Туршилт хийх	Нэвтрүүлэх		УТ 3,000.0	ЦУОШГ, УЦУОШТ
Үйл ажиллагааны чиглэл 2.6. Азийн улс орны нислэгийн цаг уурын байгууллагын жишигт хүрсэн агаарын навигацгийн цаг уурын үйлчилгээ үзүүлнэ.										
48	WAFS кодын тайлал хийх, ОУИНБ-ын стандарт шаардлагыг хангах дээд агаарын зайн цаг агаарын аюултай үзэгдлийн зураглал хийх,	Ажлын гүйцэтгэл, хувь	0	Судалгаа хийх, мэдээлэл боловсруулах	Нэвтрүүлэх, боловсон хүчин сургах				УТ 60.0	ЦУОШГ, НЦУТ
49	Дунд өндрийн цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх арга боловсруулах, онцгой үзэгдлийн зураглал хийх	Хэрэгжилтийн явц	0		5-6 арга зүй боловсруулна	5-6 арга зүй боловсруулна	Туршилт, нэвтрүүлэлт хийнэ.	Веб суурьтай платформ хөгжүүлнэ.	УТ 200.0	ЦУОШГ, НЦУТ
50	ДЦУБ, ОУИНБ-ын төлөвлөлтийн дагуу SWIM концепцийн хүрээнд IWXXM хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн үе шат	IWXXM 3.0 хувилбарын дагуу кодын хөрвүүлэх программ хийгдсэн	Дотоод болон олон улсад мэдээ дамжуулах, програмын туршилт хийх	Үйлдвэрлэлд нэвтрүүлэх	Сайжруулалт хийх	Сайжруулалт хийх	Сайжруулалт хийх	УТ 300.0	ЦУОШГ, НЦУТ
51	Нислэгт зориулсан бүх төрлийн цаг уурын үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулахад шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмжөөр хангах	Ажлын гүйцэтгэл, хувь программ хангамжийн тоо	10	5	5	10	10	10	УТ 70.0	ЦУОШГ, НЦУТ
52	Хиймэл оюун ухаан ашиглаж нислэгийн цаг уурын AUTO TAF гаргах	Үйл ажиллагааны явц,	0		Арга боловсруулах	Нэвтрүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах			УТ, ГЗТ 100.0	ЦУОШГ, НЦУТ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилт 3. Тогтвор суурьшилтай, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа										
Үйл ажиллагааны чиглэл 3.1: Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлан хэрэгжүүлнэ.										
53	Салбарын холбогдох албан хаагчдыг амь насны даатгалд хамруулах	Даатгалд хамруулсан албан хаагчдын тоо	195	198	382	480	480	480	УТ 113.6	ЦУОШГ БОАЖЯ
54	Орон нутагт ажиллаж буй ажилтан, албан хаагчдад таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох	Үйл ажиллагааны явц	0	Ажлын хэсэг байгуулагдаж төсөл боловсруулсан байна	Саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна	Хэрэгжилтийг хангаж ажиллана			УТ	БОАЖЯ ЦУОШГ
55	Албан хаагчдыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Хангалтын төсөв, сая төгрөг	9.3	Жишиг баримт бичиг боловсруулж баталсан байна.	10.0	15.0	20.0	25.0	УТ 70.0	ЦУОШГ
56	Цаг уурын өртөөдийн барилгыг шинэчлэх	Их засвар хийсэн барилгын тоо, Шинээр баригдсан барилгын тоо,	-	31 7	28 10	25 10	20 10	15 10	УТ	ЦУОШГ БОАЖЯ
57	Стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар хангах	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо	16	10	15	20	25	30	УТ 1,000.0	ЦУОШГ БОАЖЯ
58	Архив, мэдээллийн сан хөмрегийн өрөөг өргөтгөх	Өргөтгөсөн хөмрегийн байрны тоо	-	-	ТЗҮ боловсруулж батлуулсан байна.	1	1	1	УТ 360.0	ЦУОШГ УЦУОШТ
Үйл ажиллагааны чиглэл 3.2. Хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулна.										
59	"Цаг уурч", "Ус судлаач" мэргэжлийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлд хамруулах	Тэргүүлэх болон Эрэлттэй мэргэжлийн чиглэлд хамруулсан эсэх /тийм, үгүй/	0	тийм					УТ	ЦУОШГ БОАЖЯ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
60	Дотоодын болон олон улсын сургалтад хамруулах	Мэргэшүүлэх сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	130	130	150	160	170	180	УТ	ЦУОШГ БОАЖЯ
61	Бакалавр, магистр докторын тэтгэлэгт сургалтад хамруулах	Тэтгэлэг олгосон суралцагчдын тоо	0	15	10	10	10	10	УТ	БОАЖЯ ЦУОШГ
62	Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй салбарын 10 албан хаагчийг гүнзгийрүүлсэн сургалтад хамруулж, англи хэлний өндөр түвшний чадвартай болгох	Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	0	2	2	2	2	2	ГЗТ, УТ 40.0	БОАЖЯ, ЦУОШГ
Үйл ажиллагааны чиглэл 3.3. "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомжид хүний нөөцийн чадавх бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах болон бусад асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.										
63	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Хэрэгжилтийн явц	-	Хуулийн төсөл боловсруулна	Батлуулна				УТ	БОАЖЯ ЦУОШГ
64	Нийгмийн баталгааг хангах чиглэлээр хуульд өөрчлөлт оруулах	Хэрэгжилтийн явц	-	Хуулийн төсөл боловсруулна	Батлуулна	Ц			УТ	ЦУОШГ БОАЖЯ
65	Цаг уур, орчны хяналт, шинжилгээний салбар нь Тусгайлан чиг үүрэгтэй байгууллага болгох	Тусгайлан чиг үүрэгтэй болсон эсэх /тийм, үгүй/	-	тийм					УТ	БОАЖЯ ЦУОШГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ